

# APU COMPANY

Absolute. Pure. Unique.





**2017 ОНЫ 08 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ**

# **АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурын дэг**

Хурал 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 14:00 цагт эхэлж, 18:00 цагт дуусна.

<b>№</b>	<b>Хэлэлцэх асуудал</b>	<b>Шийдвэрийн төсөл</b>	<b>Хугацаа</b>	<b>Хариуцах эзэн</b>
1	Хуралд оролцогчдыг бүртгэх, саналын хуудас тарааж өгөх		13:00-13:50	Хурал зохион байгуулах комисс
2	Бүртгэлийн ажиллагааны дүнг гаргах	Тооллогын комиссын тогтоол	13:50-14:00	Тооллогын комисс
3	Хурлын зохион байгуулалтын асуудал, хурлын дарга хурлыг нээх		14:00-14:02	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
4	АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	14:02-14:25	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
5	Асуулт, хариулт		14:25-14:40	
6	АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх төсөл, нэгтгэх гэрээг батлах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	14:40-15:20	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
7	Асуулт, хариулт		15:20-15:40	
8	АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	15:40-15:55	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
9	Асуулт, хариулт		15:55-16:05	
10	АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	16:05-16:20	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
11	Асуулт, хариулт		16:20-16:30	
12	АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	16:30-16:40	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
13	Асуулт, хариулт		16:40-16:50	
14	Саналын хуудас бөглөх санамж өгөх		16:50-16:55	Тооллогын комисс
15	Хэлэлцэх асуудлаар саналын хуудас бөглөж өгөх		16:55-17:10	
16	Санал тоолох ажиллагаа		17:10-17:50	Тооллогын комисс
17	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	17:50-17:55	Тооллогын комисс
18	Хурлын хаалтын ажиллагаа		17:55-18:00	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг

# АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал

- 1) АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай;
- 2) АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл (цаашид “нэгтгэх төсөл” гэх), нэгтгэх гэрээг батлах тухай;
- 3) АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах тухай;
- 4) АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
- 5) АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;

*Жич: Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах, хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргах болон тэдгээртэй холбоотой бусад асуудалд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн журам үйлчилнэ.*

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ТА БҮХЭН хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй 2017 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хооронд ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд АПУ ХК-ийн байранд хурал зохион байгуулах комисстой холбогдон танилцах боломжтой.

**Хурал зохион байгуулах комиссын дарга:**

Х.Батжаргал batjargal@apu.mn 11-344837

**Хурал зохион байгуулах комиссын гишүүд:**

Ч.Ариунсан ariunsan@apu.mn 11-344837-315  
Б.Эрдэнэтуяа erdenetuya@apu.mn 11-344837-312  
Э.Солонго solongo.e@apu.mn 11-344837-322

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## **Хэлэлцэх асуудал №1.**

**АПУ ХК-ИЙГ ТУСГААРЛАХ ЗАМААР  
ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ШИНЭЭР ОХИН  
КОМПАНИ ҮҮСГЭН БАЙГУУЛАХЫГ  
ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

# Сүүний бизнесийг Тусгаарлах үндэслэл

## **Үндэслэл 1:**

АПУ ХК-н дунд болон урт хугацааны стратегийн зорилгын хүрээнд тусгагдсаны дагуу сүүний бизнес нэгжийг бие даасан ашгийн төв болгох

## **Үндэслэл 2:**

Хөрөнгө оруулагчдад компанийн бизнес бүрийн үнэ цэнийг үнэлэхэд илүү тодорхой болгох


## **Үндэслэл 3:**

Сүүний бизнес нэгжид стратегийн түншлэлийг бий болгох суурь тавигдах

## **Үндэслэл 4:**

Хэрэглэгчдэд чанартай, шинэ бүтээгдэхүүнийг шуурхай хүргэхийн тулд сүү бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын хэлхээний нэгдсэн удирдлагын тогтолцоог бий болгох

# Тусгаарласны дараах бүтэц зохион байгуулалт



## СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ



Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ 2021 он гэхэд 60 сая литрт хүрэхээр байна. АПУ ХК-ийн хувьд 2017-оос 2021 оны хооронд жилд дунджаар 17%-иар борлуулалтаа өсгөн 2021 онд нийт зах зээлийн 34%-ийг эзлэхээр зорьж байна

Хүснэгт 1. Сүү, сүүн бүтээгдэхүүний цэвэр борлуулалтын орлого, сая.төг

	2017 төл.	2018 төл.	2019 төл.	2020 төл.	2021 төл.
Сүү, сүүн бүтээгдэхүүн	22,358	28,319	34,765	42,130	50,291

# Тусгаарласан компанийн эхлэлтийн баланс

Хүснэгт 2. Эхлэлтийн баланс, сая.төг

<b>Хөрөнгө</b>		<b>Эх үүсвэр</b>	
Эргэлтийн хөрөнгө	19,121	Эздийн өмч	54,619
Эргэлтийн бус хөрөнгө	35,498		
<b>Нийт</b>	<b>54,619</b>	<b>Нийт</b>	<b>54,619</b>



# АПУ ХК-ийг Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

ТӨСӨЛ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр, сүүний бизнестэй холбогдох үйл ажиллагаа, дагалдах Хөрөнгө, үүрэг, хариуцлагыг тусгаарлан Компанийн 100%-ийн хөрөнгө оруулалттай хуулийн этгээд (цаашид “Охин компани” гэх) байгуулан шилжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Энэ журмын зорилго нь Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах ерөнхий дарааллыг тогтоох, тусгаарлах комиссыг томилох, түүний чиг үүргийг тодорхойлох, Компанийн балансыг тусгаарлах, Компанийн хөрөнгийг Охин компанид шилжүүлэх, Охин компани байгуулах түүнд эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх арга зам, дарааллыг тодорхойлохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 2.1. Компани нь өөрийн балансад бүртгэлтэй дор дурьдсан эрх, оюуны үнэт зүйл, эд хөрөнгө, түүнийг өмчлөх, эзэмших эрх, тэдгээртэй холбоотой үүрэг, хариуцлага, хууль ёсны ашиг сонирхлыг өөрийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр хуульд заасан журмын дагуу тусгаарлаж Охин компанийн балансад шилжүүлнэ. Үүнд:
  - 2.1.1 Хөрөнгийн эрх, үүрэг:
    - 2.1.1.1 Эд хөрөнгө (хавсралт №1);
    - 2.1.1.2 Оюуны өмч (хавсралт №2);
    - 2.1.1.3 Сүүний үйлдвэрийн барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгүүд болон газрын түрээсийн гэрээний түрээслэгчийн эрх, үүрэг (хавсралт №3);
  - 2.1.2 Үйл ажиллагаа явуулах эрх, үүрэг:
    - 2.1.2.1 Сүү, сүүн бүтээгдэхүүн, зарим төрлийн жүүс, шүү үйлдвэрлэл эрхлэх эрх (хавсралт №4);
    - 2.1.2.2 Сүүний бизнесийн нэгжийн ажил олгогчийн эрх, үүрэг (хавсралт №5);
- 2.2. Компания тусгаарлах нийт хөрөнгө нь 54,619,000,000₮ (тавин дөрвөн тэрбум зургаан зуун арван есөн сая төгрөг) байна.

№	Үзүүлэлтийн нэр	Актив /төгрөгөөр/	Пассив /төгрөгөөр/
1	Эргэлтийн хөрөнгө	19,120,844,000	
2	Эргэлтийн бус хөрөнгө	35,498,156,000	
3	Толгой компаниас оруулсан хөрөнгө оруулалт		54,619,000,000
	<b>НИЙТ</b>	<b>54,619,000,000</b>	<b>54,619,000,000</b>

## Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

- 2.3 Эргэлтийн бус хөрөнгийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр гарсан өдрийн байдлаар элэгдэл хорогдлыг тооцон шилжүүлнэ.
- 2.4 Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь энгийн хувьцаанд хөрвөж, Охин Компанийн санхүүгийн тайлан балансын эздийн өмчийн хэсэгт, Компанийн тусгаарласан хөрөнгө балансын “хөрөнгө” хэсгээс хасагдаж, “хөрөнгө оруулалт” хэсэгт бүртгэгдэнэ.
- 2.5 Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулсан нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, зарласан энгийн хувьцааны тоо ширхэг, энгийн хувьцааны нэрлэсэн үнэд өөрчлөлт оруулахгүй болно.
- 2.6 Охин компани нь Компаниас тусдаа бие даасан тайлан баланс, эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах хариуцлагыг өөрийн эд хөрөнгөөрөө хариуцах бие даасан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байна.
- 2.7 Тусгаарлах үйл ажиллагаа нь Компанийг үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх ба Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.
- 2.8 Компани нь Хөрөнгө тусгаарлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана

### **ГУРАВ. ТУСГААРЛАХ КОМИСС, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

- 3.1. Хөрөнгө тусгаарлах үйл ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Тусгаарлах комисс ажиллана.
- 3.2. Тусгаарлах комисс нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:
  - 3.2.1 Шударга байх;
  - 3.2.2 Албан үүрэгтээ хариуцлагатай хандах;
  - 3.2.3 Үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөх;
  - 3.2.4 Компанийг өөрчлөн байгуулах ажиллагааг хурдан, шуурхай хэрэгжүүлэх.
- 3.3. Тусгаарлах комисс нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 3.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн Компанийг хуваах балансыг эцэслэн боловсруулж, батлуулах;
  - 3.3.2 Компанийг өөрчлөн байгуулагдаж байгаа тухай мэдэгдлийг Компанийн харилцагч, зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч, сонирхогч этгээд нарт хуульд заасан журмын дагуу мэдэгдэх;
  - 3.3.3 Холбогдох Хөрөнгийг шилжүүлэх хүсэлтийг харьяа эрх бүхий байгууллагад гаргаж Охин компанийн нэр дээр шилжүүлж гэрчилгээ, гэрээг байгуулж баталгаажуулах;

# АПУ ХК-ийг Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

ТӨСӨЛ

- 3.3.4 Компанийг тусгаарлах болон Охин компанийг бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг бэлтгэж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх;
- 3.3.5 Компанийг тусгаарлахтай холбоотойгоор өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн ажилтнуудыг шинээр үүсгэн байгуулагдаж байгаа охин компанид шилжүүлэн ажиллуулахтай холбоотой үүсэх хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
- 3.3.6 Компани өөрчлөн байгуулагдаж дууссаны дараа өөрчлөн байгуулагдсан компани болон Охин компанийн үндсэн хөрөнгөд тооллого явуулж, хүлээлцэх;
- 3.3.7 Оюуны өмч, барааны тэмдэгт, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, гэрчилгээ, стандартчилал, тохирлын үнэлгээ зэрэг шинээр үүсгэн байгуулагдах компанийн бизнесийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
- 3.3.8 Энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 3.3.9 Өөрчлөн байгуулахтай холбоотой бусад шаардлагатай ажиллагааг Компанийн ТУЗ-ийн зааварчилгааны дор гүйцэтгэх.

## **ДӨРӨВ. ХУВААХ БАЛАНС ГАРГАХ, БАТЛАХ**

- 4.1. Хуваах балансыг дараах байдлаар гаргаж, Компанийн ТУЗ-ийн хурлаар батлуулна. Үүнд:
  - 4.1.1. Хуваах балансыг хууль тогтоомжид нийцүүлэн Тусгаарлах комисс эцсийн байдлаар үйлдэх бөгөөд балансаас тусгаарлах нийт хөрөнгийн хэмжээ 54,619,000,000₮ (тавин дөрвөн тэрбум зургаан зуун арван есөн сая төгрөг) байна.
  - 4.1.2. Хуваах балансад үндэслэн Охин компанид оруулсан хөрөнгийн хэмжээг тодорхойлох ба хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Охин компанийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр батална.

## **ТАВ. КОМПАНИЙН ӨР, ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖУРАМ**

- 5.1. Компанийн өр төлбөрийг дараах журмын дагуу барагдуулна. Үүнд:
  - 5.1.1. Хуваах балансад заасны дагуу Компани нь өөрийн төлбөл зохих татварын өр төлбөр, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн өөрийн бүх үүргийг хариуцна;
  - 5.1.2. Охин компанид шилжүүлсэн тоног төхөөрөмжийн зээлийн гэрээний болон барьцааны гэрээний үүрэг, өр төлбөрийг шилжүүлэхгүй бөгөөд Компани дангаар хариуцна.
  - 5.1.3. Замд яваа бараа бүтээгдэхүүний улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой гаалийн татвар, хураамжийг өөрчлөн байгуулагдаж буй Компани хариуцна.

# АПУ ХК-ийг Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

ТӨСӨЛ

## **ЗУРГАА. КОМПАНИ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАГДСАНЫГ МЭДЭГДЭХ**

- 6.1. Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрчлөн байгуулагдсан тухай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх ажлыг Тусгаарлах комисс хариуцан зохион байгуулна.
- 6.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрчлөн байгуулагдсан тухай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор тусгаарлах комисс нь харилцагчдад компани тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан тухай мэдэгдэнэ.
- 6.3. Тусгаарлах комисс нь компани өөрчлөн байгуулагдсан тухай мэдэгдэнэ.
- 6.4. Компани өөрчлөн байгуулагдсаныг Тусгаарлах комисс эрх бүхий бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

## **ДОЛОО. ОХИН КОМПАНИ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ**

- 7.1. Охин компанийг үүсгэн байгуулах шийдвэр, дүрмийг шийдвэрт томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч эрх бүхий бүртгэлийн байгуулагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлнэ.
- 7.2. Охин компанийг харьяалагдах татвар хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

# АПУ ХК-ийг Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

ТӨСӨЛ

## НАЙМ. ХӨРӨНГӨ, ЭРХ ҮҮРЭГ ТУСГААРЛАХ ПРОЦЕСС

- 8.1. Хөрөнгө тусгаарлахтай холбоотойгоор дараах ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 8.1.1. Шилжиж буй эд хөрөнгийг хөрөнгийн жагсаалтыг үндэслэн тусгаарлах шийдвэр гарсан үеийн байдлаар бараа материалыг тооллого хийж, хүлээлгэж өгөх бөгөөд энэ тухай хүлээлцсэн акт үйлдэнэ.
  - 8.1.2. Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох ISO22000:2005 стандартыг нэвтрүүлсэн үйлдвэр болохыг SGS олон улсын аудитад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх;
  - 8.1.3. Барааны тэмдгийн гэрчилгээ, патентийн гэрчилгээ, барааны тэмдгийн мэдүүлгийн эрх эзэмшигч өөрчлүүлэх хүсэлтийг Монгол Улсын Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргаж шийдвэрлүүлэх;
  - 8.1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүн, зарим жүүсний тохирлын гэрчилгээ эзэмшигч өөрчлүүлэх хүсэлтийг Стандартчилал, хэмжил зүйн газарт хандаж шийдвэрлүүлэх;
  - 8.1.5. Сүүний Лабораторийн итгэмжлэлийн гэрчилгээний эзэмшигч өөрчлүүлэх хүсэлтийг Стандартчилал, хэмжил зүйн газарт хандаж шийдвэрлүүлэх;
  - 8.1.6. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний нэр шилжүүлэх хүсэлтийг Авто тээврийн үндэсний төвд хандаж гаргаж шийдвэрлүүлэх;
  - 8.1.7. Хөдлөх эд хөрөнгө (сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн иж бүрдэл)-ийн өмчлөгчийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар (Хан-Уул дүүргийн эд хөрөнгийн бүртгэлийн хэлтэс)-т өөрчлүүлэх хүсэлтийг гаргаж шийдвэрлүүлэх;
- 8.2. Тусгаарлах комиссын шийдвэрийг Компани болон Охин компанийн Гүйцэтгэх удирдлага бусад эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нь тус тусын хариуцсан чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 8.3. Компанийг тусгаарлах үйл ажиллагааны тайланг Компанийн ТУЗ-д танилцуулах үүргийг Тусгаарлах комисс хүлээнэ.

# АПУ ХК-ийг Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журам

ТӨСӨЛ

## ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 9.1. Энэхүү нөхцөл, журмын төсөлд заасан Компанийн ажлын байр, алтушаалтан, ажилтнуудыг шилжүүлэх, ажил олгогчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг Тусгаарлах комисс болон Компани болон Охин компанитай хамтран Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээг удирдлага болгон зохион байгуулж ажиллана.
- 9.2. Охин компанийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг Охин компани, түүний удирдлага хариуцан зохион байгуулна.
- 9.3. Тусгаарлах ажиллагааны үед компанийн ажилтнууд нь компанийн өмч хөрөнгийг аливаа байдлаар ашиглан шамшигдуулахгүй байх үүрэгтэй ба үүнд тусгаарлах комисс хяналт тавина.
- 9.4. Охин Компанийн бүтэц орон, тоо, Хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулан батлуулах ажлыг ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу Охин компанийн удирдлага гүйцэтгэж, тусгаарлах комисс хяналт тавьж ажиллана.

## АРАВ. ХАРИУЦЛАГА

- 10.1. Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан холбогдох этгээдүүд хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.
- 10.2. Энэхүү журамд заасан үүргээ гүйцэтгээгүй, компанийн нууц мэдээллийг задруулсан тохиолдолд ажилтанд компанийн хөдөлмөрийн дотоод журам болон компанийн холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

## АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Энэхүү журам нь Компанийг өөрчлөн байгуулах ажиллагаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

## Эд хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн жагсаалт	Дүн /төгрөг/
1	Тавилга эд хогшил	137,777,000.00
2	Компьютер дагалдах хэрэгсэл	65,884,000.00
3	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	34,105,878,000.00
4	Барилгын тоног төхөөрөмж	48,348,000.00
5	Тээврийн хэрэгсэл	1,120,032,000.00
6	Бусад хөрөнгө	20,237,000.00
	НИЙТ	35,498,156,000.00

АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн  
байгуулах нөхцөл, журмын 2-р хавсралт

1. Барааны тэмдгийн гэрчилгээ- 27
2. Патентийн гэрчилгээ- 4

АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн  
байгуулах нөхцөл, журмын 3-р хавсралт

## Сүүний үйлдвэрийн барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгүүд болон газар буюу түрээсийн зүйлсийн жагсаалт

1. АПУ ХК-ийн Капитал групп ХХК-тай байгуулсан Түрээсийн гэрээний зүйлс:

№	Нэр	Гэрчилгээний дугаар	Улсын бүртгэлийн дугаар
1	Сүүний үйлдвэрийн барилга	000188611	Ү-2206005068
2	Оффисийн барилга	000188608	Ү-2206021155
3	Шил угаах цехийн барилга	000188610	Ү-2206021157
4	Гаражийн барилга	000188609	Ү-2206021156
5	Агуулахын барилга	000078764	Ү-2206005067
6	Газар ашиглах эрх, түүний хил хязгаарыг тодорхойлж байгаа хашааны хамт	0001112	22,900 м.кв талбай

# Сүү, сүүн бүтээгдэхүүн, зарим төрлийн жүүс, шүүсний үйлдвэрлэл эрхлэх эрх

ТӨСӨЛ

## 1. Баталгаажилтын гэрчилгээний жагсаалт

№	Гэрчилгээний нэр	Гэрчилгээний дугаар	Олгосон газар	Хүчинтэй хугацаа
1	ISO 22000:2005 гэрчилгээ	CN13/88621	SGS	2017-11-06
2	Сүүний лабораторийн Итгэмжлэлийн гэрчилгээ	TL 18-02	СХЗГ	2018-11-04
3	Тохирлын гэрчилгээ	УБД0000904	СХЗГ	2019-09-29
4	Тохирлын гэрчилгээ	УБД0000790	СХЗГ	2019-03-04
5	Тохирлын гэрчилгээ	УБД0000912	СХЗГ	2017-09-29
6	Тохирлын гэрчилгээ	УБД0000526	СХЗГ	2017-10-30

## 2. Үйлдвэрлэлийн баримт бичгийн жагсаалт:

№	Баримт бичгийн нэр	Агуулга	Тоо ширхэг
1	Сүү, жүүсний үйлдвэрийн технологийн зааврууд	Бүтээгдэхүүний жор, орц норм, технологийн ерөнхий зааврууд	9
2	Сүү, жүүсний үйлдвэрийн ажлын зааврууд	Үйлдвэрлэлийн явц дахь ажлын зааврууд	11
3	Сүүний үйлдвэрийн OPRP журмууд	Шаардлагатай мөрдөгдөх хяналтын журмууд	4

АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмын 5-р хавсралт

Сүүний бизнесийн нэгжийн бүтцийн орон тоо- 106



## **“АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад байгуулагдсан “АПУ ДЭЙРИ” ХХК (цаашид “Компани” гэх) нь Компанийн хуульд заасны дагуу өөрийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх) -ийг батлав.

### **ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР**

- 2.1. Компанийн оноосон нэр:
  - 2.1.1. Монголоор: “АПУ ДЭЙРИ ХХК”;
  - 2.1.2. Англиар: “APU DAIRY LLC” гэж нэрлэнэ.
- 2.2. Компанийн оршин байгаа газар, албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 33/5 тоот; Утас: 99114718;
- 2.3. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ**

- 3.1. АПУ ДЭЙРИ ХХК нь (цаашид “Компани” гэх) Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна. Компани нь хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.
- 3.2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаадын болон Монголын байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.
- 3.3. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 3.4. Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газраа байгуулж болно.
- 3.5. Компани нь өөрийн “АПУ ДЭЙРИ” ХХК гэсэн нэрийг бүх үйл ажиллагаандаа ашиглана.
- 3.6. Компани нь дотоод, гадаадын банкинд төгрөг болон гадаад валютын данстай байна.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 4.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:
  - 4.1.1. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
  - 4.1.2. Жүүс, ундаа үйлдвэрлэл;
  - 4.1.3. Сүү, сүүн бүтээгдэхүүн, жүүс, ундааны бөөний болон жижиглэнгийн худалдаа;
  - 4.1.4. Гадаад худалдаа.

## ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 5.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 54,619,000,000 (тавин дөрвөн тэрбум зургаан зуун арван есөн сая) төгрөг байна.
- 5.2 Компанийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо 546,190,000 (таван зуун дөчин зургаан сая нэг зуун ерэн мянга) ширхэг энгийн хувьцаа байна. Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуу) төгрөг байна.
- 5.3 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:
  - 5.3.1 нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх эсхүл бууруулах;
  - 5.3.2 хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;
  - 5.3.3 өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

## ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

- 6.1 Компани нь 1 (нэг) Хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 хувь эзэмшинэ:

Хувьцаа эзэмшигчийн нэр, регистрын дугаар	Хаяг	Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо	Нэгж үнэ	Эзэмшиж буй хувьцааны үнэ	Эзэмшлийн хувь хэмжээ
		Энгийн хувьцаа, ширхэг	төгрөг	төгрөг	хувь
“АПУ” Хувьцаат компани Reg №: 2702673	Монгол улс, Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-14, Өөрийн байр	546,190,000	100	54,619,000,000	100%

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## **ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1 Компанийн энгийн Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 7.1.1 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
  - 7.1.2 эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
  - 7.1.3 Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
  - 7.1.4 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
  - 7.1.5 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;
  - 7.1.6 Компанийн болон бусад Хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон Компанийн Дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах;
  - 7.1.7 Компанийн нууцыг чандлан хадгалах;
  - 7.1.8 Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх.

## **НАЙМ. КОМПАНИЙН УДИРДЛАГА**

- 8.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн цор ганц хувьцаа эзэмшигч болох АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.
- 8.2 Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-тэй байж болно.
- 8.3 Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг Компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

- 9.1 Дараах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 9.1.1 Компанийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
  - 9.1.2 нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;
  - 9.1.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
  - 9.1.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 9.1.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 9.1.6 хувьцааг хуваах буюу нэгтгэх;
  - 9.1.7 Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ТУЗ-ийн гишүүдийг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох, цалин, урамшууллыг тогтоох;
  - 9.1.8 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 9.1.9 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй их хэмжээний хэлцлийг батлах;
  - 9.1.10 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
  - 9.1.11 Компанийн тухай хуульд заасны дагуу Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
  - 9.1.12 Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан;
  - 9.1.13 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ-аас оруулсан болон, Компанийн тухай хуулиар тогтоосон бусад асуудал.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## АРАВ. ТУЗ

- 10.1. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн тоо нь 9 хүртэл байх ба Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ бүрэлдэхүүнийг сонгоогүй тохиолдолд ТУЗ-ийн бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн хурал хэрэгжүүлнэ.
- 10.2. ТУЗ нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 10.2.1. Энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
  - 10.2.2. Компани үнэт цаас гаргах;
  - 10.2.3. Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох;
  - 10.2.4. Компанийн Гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
  - 10.2.5. Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтоох;
  - 10.2.6. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
  - 10.2.7. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
  - 10.2.8. Компанийн аудиторыг сонгох, гэрээний нөхцлийг тогтоох;
  - 10.2.9. Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
  - 10.2.10. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;
  - 10.2.11. Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
  - 10.2.12. Компанийг өөрчлөн байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
  - 10.2.13. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 10.2.14. Гүйцэтгэх удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлыг шийдвэрлэх;
  - 10.2.15. Энэ Дүрэм, Компанийн тухай хуульд заасан бусад асуудлууд.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 11.1. Компанийн Гүйцэтгэх захирал нь энэ Дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 11.2. Гүйцэтгэх удирдлага өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх зэргээр Компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 11.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 11.4. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заана.
- 11.5. Гүйцэтгэх захирал өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. Үүнд:
  - 11.5.1. энэхүү Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
  - 11.5.2. Компанийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
  - 11.5.3. Компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
  - 11.5.4. ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
  - 11.5.5. Компанийн гэрээ хэлцэл, албан захидал, баримт бичигт гарын үсэг зурах;
  - 11.5.6. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
  - 11.5.7. энэхүү Дүрэмд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх;
  - 11.5.8. Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, Компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцлагчаар оролцох, эсхүл Компанийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
  - 11.5.9. Компаниас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;
  - 11.5.10. Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн хяналт хийх байгууллагатай гэрээ байгуулах, хяналт хийлгэх, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;
  - 11.5.11. Компанийн Гүйцэтгэх удирдлага Компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;
  - 11.5.12. гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

- 11.6. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх болон шаардлагатай бусад тохиолдолд өөрийн эрх, үүргийг өөрийн томилсон этгээдэд шилжүүлнэ. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **АРВАН ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 12.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан:
- 12.1.1. Гүйцэтгэх захирал;
  - 12.1.2. Ерөнхий нягтлан бодогчтой адилтгах санхүү хариуцсан захирал, дарга;
  - 12.1.3. ТУЗ-ийн бүрэлдэхүүн сонгогдсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 12.2. Компанийн үйл ажиллаганы цар хүрээнээс хамааруулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зохих албан тушаалтнуудыг Компанийн эрх бүхий этгээдээр тооцно.
- 12.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаатай, шууд буруутай үйл ажиллагаа, хайнга хайхрамжгүй байдлаас компанид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх хариуцлага хүлээнэ.

# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## **АРВАН ГУРАВ. ТАТВАР НОГДУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН, НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ**

- 13.1. Компанийн санхүүгийн жил нь бүртгэгдсэн өдрөөс эхэлж 12-р сарын 31-ний өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 1-р сарын 1-ний өдөр эхлэж татан буулгасан өдөр дуусна. Бусад онд санхүүгийн жил нь 1-р сарын 1-ний өдөр эхлэж 12-р сарын 31-ний өдөр дуусна.
- 13.2. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлнө.
- 13.3. Компанийн сонгосон аудитор нь Монгол Улсын болон олон улсын нягтлан бодох стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий нягтлан бодогч буюу нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шаардлагаар Компанийн санхүүгийн баримт бичгийг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.
- 13.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аливаа татвар, төлбөрүүдийг зохих ёсоор төлнө.
- 13.5. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын татварыг улсын төсөвт төлсний дараа Компани өөрийн санхүүгийн байдлаас хамааран Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад санг байгуулж болно.
- 13.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу элэгдлийн сан байгуулна.
- 13.7. Компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланд хийх жилийн аудитыг хөндлөнгийн аудитор хийх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Монгол Улсын холбогдох байгууллагад гаргаж өгнө.
- 13.8. Компани нь Компанийн тухай хууль болон Компаниас батлан гаргасан ногдол ашиг хуваарилах бодлогод нийцүүлэн ногдол ашиг хуваарилж болно.



# “АПУ Дэйри” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төсөл

## **АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ**

- 14.1. Компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр буюу шүүхийн шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болно.
- 14.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-29 дүгээр зүйлүүдийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 14.3. Компанийг татан буулгасан тохиолдолд түүний өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр хуваарилна.
- 14.4. Компанийг өөрчлөн байгуулах буюу татан буулгах ажлыг Компанийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

## **АРВАН ТАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА**

- 15.1. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

## **АРВАН ЗУРГАА. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ**

- 16.1. Энэхүү Дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, нэмэлт өөрчлөлт оруулах, түүний заалтууд хүчин төгөлдөр бус болох асуудал Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана.

## **АРВАН ДОЛОО. БУСАД**

- 17.1. Энэхүү Дүрмийг 3 [гурав] хувь үйлдэж, Хувьцаа эзэмшигч нэг хувийг, нэг хувийг бүртгэх байгууллагад, үйлдсэн нэг хувийг Компани өөртөө хадгална.
- 17.2. Энэхүү Дүрэм нь Компани бүртгэх байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 17.3. Энэхүү Дүрэм нь Компанийн үндсэн баримт бичиг байна.
- 17.4. Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:**

---

/гарын үсэг/

гарын үсгийн тайлал

## **Хэлэлцэх асуудал №2.**

**АПУ ХК-Д ЭВЭРГРИЙН ИНВЕСТМЕНТС  
ХХК-ИЙГ НЭГТГЭХ ЗАМААР ӨӨРЧЛӨН  
БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРӨХ, НЭГТГЭХ  
ТӨСӨЛ, НЭГТГЭХ ГЭРЭЭГ БАТЛАХ  
ТУХАЙ**

# Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах үндэслэл

АПУ ХК ба Эвэргрийн Инвестментс ХХК-н нэгдлийн дүнд хоёр компанийн хөрөнгө, нөөц боломжийг хамгийн зохистой байдлаар нэгтгэж, шингэн хүнсний салбарт шинэ үнэ цэнийг бий болгоно.

## Нэгдлийн үр дүнд:

- Дэлхийн түвшний стратегийн хөрөнгө оруулагч, түнштэй (HEINEKEN) болсноор үйл ажиллагаа, компанийн засаглалыг хөгжлийн шинэ шатанд гаргана: HEINEKEN-н Глобал ноухау-г нэвтрүүлж, хэрэглэгчдэд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн шилдэгээр баяжуулна. Компанийн засаглалд олон улсын тэргүүний туршлагыг нэвтрүүлж, Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулна.
- АПУ ХК Монгол улсын шингэн хүнсний тэргүүлэгч компани, бүс нутгийн болон олон улсын зах зээлийн тоглогч болно: Одоогийн бизнесийг газарзүйн бусад гол бүсүүд рүү тэлэх (Зүүн Өмнөд Ази, Европын Холбоо, Хойд Америк) ажиллагаа бодитоор хэрэгжиж, экспортын орлогыг дорвитой өсгөн, импортыг бууруулна.
- Хувьцаа эзэмшигч, харилцагч, хэрэглэгч, компанийн хамт олонд өндөр ач холбогдол бүхий үнэ цэнийг бий болгоно:
  - Үйлдвэрлэл, түгээлтийн сүлжээний далайцыг өргөжүүлж, Heineken-н олон улсын худалдан авалтын боломжийг ашиглан, үйлдвэрлэлийн өртөг, борлуулалт, удирдлагын зардлыг бууруулах замаар **үйл ажиллагааны синерги бий болгож, ашиг орлогыг нэмэгдүүлэн, компанийн зах зээлийн үнэлгээг өсгөхийн зэрэгцээ ногдол ашгийн хуваарилалтыг нэмэгдүүлнэ.**
  - Хоёр компанийн давуу талуудыг хослуулан, маркетинг түгээлтийн үйлчилгээнд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлж, **харилцагчдыг шилдэг бүтээгдэхүүн ба үйлчилгээгээр хангана.**
  - Хэрэглэгчдэд дээд зэргийн чанар, сонголт бүхий, гадаад дотоодын тэргүүлэх брэндээс бүрдсэн бүтээгдэхүүний багцыг **санал болгон, хариуцлагатай хэрэглээг эрхэмлэн ажиллана.**
  - Ажлын байрны тогтвортой байдлыг хангаж, компанийн хамт олонд дэлхийн дэвшилтэт технологи, үйл ажиллагаа, засаглалын шилдэг туршлагаас суралцан, **хувь хүний хөгжилд үсрэнгүй ахиц дэвшил гаргах боломжийг олгоно.**
- Татвар төлөлт, нийгмийн хариуцлагын хэрэгжилтээр тэргүүлэгч байр сууриа бататган, дотоодын эдийн засагт оруулах хувь нэмрээ нэмэгдүүлнэ: Улсын төсөвт төлөх татварын хэмжээг нэмэгдүүлж, чөлөөт өрсөлдөөнийг эрхэмлэн, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах замаар олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх үйл хэрэгт хувь нэмэр оруулна.

# Стратегийн түвшний синерги

## **Зорилго:**

Нэгдлийн үр дүнд оновчтой бизнес моделийг бий болгосноор дотоодын зах зээлд амжилтаа ахиулан, олон улсын зах зээлд гарч бизнесийн үнэ цэнийг өсгөнө.

Ойрын 5 жилийн зорилтууд:

## **Экспортыг тэлнэ**

- Ойрын 5 жилийн хугацаанд нэгдсэн компанийн борлуулалтын орлогын 10% буюу 40 орчим сая долларыг экспортын орлогоор бүрдүүлж, 2021 он гэхэд архины борлуулалтын орлогын 17% -ийг экспортын орлогоор бүрдүүлнэ.

## **Дэлхийн түвшний үйл ажиллагааны болон компанийн засаглалын тогтолцоог нэвтрүүлнэ**

- Шингэн хүнсний салбарт олон улсын туршлагыг нэвтрүүлж өрсөлдөх чадвараа бэхжүүлэн, дэлхийн стандартын компанийн засаглал бүхий байгууллага болно.

## **Олон улсын хөрөнгийн зах зээл рүү гарна**

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн зах зээл дээр IPO хийж, хөрөнгө оруулалт татна.

## **Импортыг бууруулна**

- Жилд дунджаар 8 сая орчим литр импортын шар айргийг дотооддоо үйлдвэрлэнэ.

## **Бүтээгдэхүүний багцыг оновчилно**

- Дотоод гадаадын шилдэг брэндээс бүрдсэн бүтээгдэхүүний портфолиоог оновчтой удирдана.

# Үйл ажиллагааны түвшний синерги

## **Зорилго:**

Нэгдлийн үр дүнд үйл ажиллагааны үр дүнтэй синержи үүсгэн, өгөөжийг нэмэгдүүлж дунд хугацааны тогтв ортой өсөлтийг хангана.

Ойрын 5 жилийн зорилтууд:

## **Бүтээгдэхүүний өртгийг бууруулна**

- Худалдан авалт болон лонхыг эргэлтэнд оруулахаас хэмнэлт үүсгэн бүтээгдэхүүний өртгийг 26 орчим тэрбум төгрөгөөр бууруулна

## **Хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлнэ**

- Архины үйлдвэрийн хүчин чадал ашиглалтыг 65% -д хүргэнэ
- Шар айраг үйлдвэрийн хүчин чадал ашиглалтыг 76% -д хүргэнэ

## **Борлуулалт, түгээлтийн үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлнэ**


- Жил бүр дунджаар 4 тэрбум төгрөгөөр хэмнэнэ

## **Ирээдүйн хөрөнгө оруулалтыг оновчилно**

- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэгтгэснээр, давхардаж болзошгүй хөрөнгө оруулалтаас зайлсхийж, үйл ажиллаганы шинэ чиглэлд хөрөнгө оруулна.

# Бүтэц зохион байгуулалт

## НЭГДЛИЙН ӨМНӨХ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




## НЭГДЛИЙН ДАРААХ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




# Борлуулалтын таамаглал /Дотоодын зах зээл/

## АРХИ




## ПИВО



## Борлуулалтын таамаглал /Дотоодын зах зээл/

### УС, УНДАА



Хүснэгт 3. Борлуулалтын нэгдсэн төлөвлөгөө, сая литр

Нэр төрөл	2017	2018	2019	2020	2021
Архи	19.1	19.4	20.1	20.6	21.2
Шар айраг	81.5	81.4	86.6	88.1	88.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн	10.1	12.2	14.5	17.4	20.4
Ус ундаа	8.8	10.3	11.9	13.7	15.7
Нийт	119.5	123.3	133.1	139.8	145.4

## Борлуулалтын таамалал /экспортын зах зээл/

Хүснэгт 4. Экспортын борлуулалтын төлөвлөгөө, сая литр

Нэр төрөл	2017	2018	2019	2020	2021
Архи	0.07	0.12	0.30	0.55	1.00
Шар айраг	0.20	0.36	0.80	1.35	2.43
Сүү, сүүн бүтээгдэхүүн	0.02	0.07	0.14	0.19	0.24
Нийт	0.29	0.56	1.23	2.09	3.67



# ҮЙЛДВЭРЛЭЛ

Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ, сая литр

Бүтээгдэхүүний төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Спирт	7.77	7.85	8.32	8.66	9.06
Архи	19.31	19.80	20.95	21.80	22.82
Шар айраг	81.28	80.69	86.94	88.93	89.94
Ус ундаа	7.36	8.55	9.96	11.60	13.42
Жүүс	1.66	1.73	1.82	1.92	2.03
Сүү, сүүн бүтээгдэхүүн	9.75	12.29	14.68	17.53	20.50
<b>Нийт</b>	<b>127.13</b>	<b>130.91</b>	<b>142.67</b>	<b>150.43</b>	<b>157.76</b>

Хүснэгт 6. Эргэлтийн лонхны нийлүүлэлтийн төлөвлөгөө, сая ширхэг

Лонхны төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Архины лонх	5.9	4.9	7.1	7.3	7.4
Шар айрагны лонх	13.0	16.1	23.3	23.7	24.0
<b>Нийт эргэлтийн лонх</b>	<b>18.9</b>	<b>21.0</b>	<b>30.4</b>	<b>30.9</b>	<b>31.4</b>

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ АШИГЛАЛТ

Хүснэгт 7. Хүчин чадал ашиглалтын хувь

<b>Архи, спирт</b>	2017	2018	2019	2020	2021
Спирт /нэрлэг/	34%	34%	36%	38%	39%
Архи /найрах/	55%	57%	60%	62%	65%
<b>Шар айраг</b>					
Пиво /чанах, исгэх/	68%	68%	73%	75%	76%
<b>ПЕТ</b>					
Пет /ус, ундаа, шар айраг/	63%	66%	71%	74%	76%
<b>Сүү</b>					
Сүү, сүүн бүтээгдэхүүн /боловсруулах хэсэг/	29%	35%	41%	49%	56%
<b>Эргэлтийн лонх</b>					
Лонх угаалга	45%	50%	73%	74%	75%

\* Хязгаарлагч хүчин чадлаар тооцсон

# СИНЕРГИ НӨЛӨӨ

Хүснэгт 8. Синерги нөлөө, сая төгрөг

	2018 төл.	2019 төл.	2020 төл.	2021 төл.	Нийт 2018-2021 онд	Тайлбар
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,975	7,205	7,342	8,203	26,725	Түүхий эд материалын худалдан авалт болон эргэлтийн шилний нийлүүлэлтээс үүсэх
Үйл ажиллагааны зардлууд	4,245	4,511	4,653	4,838	18,247	Экспортын борлуулалтаас үүсэх
Экспортоос орж ирэх EBITDA	76	1,649	7,445	15,795	24,966	
<b>Total, Нийт</b>	<b>8,296</b>	<b>13,366</b>	<b>19,440</b>	<b>28,836</b>	<b>69,938</b>	

## АШИГТ АЖИЛЛАГАА, НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШГИЙН ӨСӨЛТ

1. Хувьсах ашгийн маржин 1.9%-р нэмэгдэнэ
2. Нийт ашгийн маржин 1.4%-р нэмэгдэнэ
3. Татварын өмнөх ашиг 2%-р нэмэгдэнэ
4. EBITDA маржин 2.5%-р нэмэгдэнэ
5. Нэгж хувьцаанд ногдох ашиг таван жилийн дунджаар 31%-р өснө.

# НЭГТГЭХ ТӨСӨЛ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү АПУ ХК-д Эвэргрийн инвестментс ХХК-ийг нэгтгэх төсөл /цаашид “Төсөл” гэх/ нь АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхээр компанийн тухай хуульд заасны дагуу нэгтгэх шийдвэр гаргах, компанийг нэгтгэх нөхцөл, журам, нэгдэж байгаа компанийн үнэт цаасыг нэгтгэж байгаа компанийн үнэт цаас, бусад хөрөнгөд хөрвүүлэх, компанийг нэгтгэсэнтэй холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компанийг нэгтгэх гэнэ.

**Нэгтгэх компанийн нэр:** АПУ ХК

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр

**Нэгдэж буй компанийн нэр:** Эвэргрийн Инвестментс ХХК

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө 48/1, Капитал хауз 4 дүгээр давхар

1.3 Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-р заалтын дагуу нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл болон компанийг нэгтгэх гэрээг компани тус бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх нь компанийг нэгтгэх эрх зүйн үндэс болно.

1.4 Компанийг нэгтгэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль журамд зохицуулагдан хийгдэнэ.

## ХОЁР. ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

2.1. АПУ ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьд:

- Нэгж хувьцаанд ногдох ашиг өснө
- Хувьцааны төвлөрөл буурч, хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдсэнээр хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэнэ
- Компанийн засаглал олон улсын жишигт хүрч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдах байдал улам сайжирна

2.2 Компанийн хөгжилд болон хэрэглэгч, харилцагчдад үзүүлэх ач холбогдол

- Бүс нутгийн хэмжээний компани болно
- Үйл ажиллагааны синерги үүсгэх замаар зардлыг бууруулна
- Харилцагч, хэрэглэгчдэд шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэнэ

2.3 МУ-ын нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдол

- Татварын орлого өснө
- Экспортын орлого нэмэгдэж, импорт буурна
- Бизнесийн сайн туршлага нутагшиж, диверсификацид хувь нэмэр болно

# НЭГТГЭХ ТӨСӨЛ

## ГУРАВ. КОМПАНИУДЫН ТАНИЛЦУУЛГА

### 3.1. Нэгтгэж байгаа компанийн товч танилцуулга

АПУ ХК нь 1924 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд архи, спирт, шар айраг, ус ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүн, жүүсний үйлдвэрлэл, бөөний худалдаа, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд юм. АПУ ХК-ийн хувьцаа нь нийтэд арилжаалагддаг, нээлттэй хувьцаат компани ба 2017 оны 03 дугаар сарын 09-ны байдлаар 3785 хувьцаа эзэмшигчидтэй, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлийн нэгдүгээр ангилалд багтах компани юм. Оросын холбооны улсад бүртгэлтэй Гранд ХХК, Их Британ Умард Ирландын Нэгдсэн Вант улсад бүртгэлтэй Чингисхаан интернэшнл ХХК гэх 100 хувийн эзэмшил бүхий хоёр охин компанитай.

### 3.2. Нэгдэж байгаа компанийн товч танилцуулга

Эвэргрийн Инвестментс ХХК нь Монгол Улсын хуулийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр үүсгэн байгуулагдсан “Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Гадаад худалдаа, Менежментийн зөвлөгөө өгөх” чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд юм. Эвэргрийн Инвестментс ХХК нь Сингапур улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Хайнекен Азия Пасифик Пте.Лтд, Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монголиан Бэвэриж Инвестментс ХХК (Шунхлай групп ХХК-ийн охин компани) гэсэн хоёр хувьцаа эзэмшигчидтэй болно. Эвэргрийн Инвестментс ХХК нь Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдүүд болох АПУ Трейдинг ХХК, Улаанбаатар спирт ХХК, Натур агро ХХК, Сингапур улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монголиан Бэвэрижс Компани Пте.Лтд (М-Би-Си Пте.Лтд) гэсэн компаниудын 100 хувийн хувьцааг эзэмшдэг.

## ДӨРӨВ. КОМПАНИУДЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ

4. Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахад хамаарагдах компаниудын хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн хувь эзэмшлийг доорх хүснэгтүүдээр харуулав.
- а. Нэгтгэж байгаа компанийн хувь эзэмшил:

АПУ ХК					
№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь	Ширхэг	Нэрлэсэн үнэ	Нийт
1	Туул Интернэшнл ХХК	51.72%	384,231,000	0.1₮	38,423,100
2	Вит Альянс Лимитэд	20.09%	149,266,000	0.1₮	14,926,600
3	Голомт Банк ХХК	19.91%	147,890,867	0.1₮	14,789,087
4	Бусад	8.28%	61,489,133	0.1₮	6,148,913
	<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>742,877,000</b>	<b>0.1₮</b>	<b>74,287,700</b>

# НЭГТГЭХ ТӨСӨЛ

## в. Нэгдэж байгаа компанийн хувь эзэмшил:

Эвэргрийн Инвестментс ХХК					
№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь	Ширхэг	Нэрлэсэн үнэ	Нийт
1	Хайнекен Азия Пасифик Пте. Лтд (ХАП)	82.82%	280,036,781	1000₮	280,036,781,400
2	Монголиан Бэвэриж инвестментс ХХК (МБИ)	17.18%	58,090,219	1000₮	58,090,218,600
	<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>338,127,000</b>	<b>1000₮</b>	<b>338,127,000,000</b>

## ТАВ. КОМПАНИЙГ НЭГТГЭХ НӨХЦӨЛ, НЭГДЭЖ БАЙГАА КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ НЭГТГЭЖ БАЙГАА КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС, БУСАД ХӨРӨНГӨД ХӨРВҮҮЛЭХ

5.1. АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 07-р сарын 06-ны өдрийн хурлын 17/22 тоот тогтоолоор хаалттай хүрээнд нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 321,304,553 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлснээр Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхээр хэлэлцэж, уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр тогтоосон.

Нэгтгэлийн өмнөх АПУ ХК  
Хувьцааны тоо: 742,877,000  
Нэрлэсэн үнэ: 10 мөнгө  
6 сарын жигнэсэн дундаж ханш: 317

69.81%

Эвэргрийн инвестментс ХХК-ийг нэгтгэхээр нэмж хувьцаа гаргах  
Хувьцааны тоо: 321,304,553  
Нэмж гаргаж буй хувьцааны нэрлэсэн үнэ: 10 мөнгө  
Нэмж гаргаж буй хувьцааны үнэ: 1,052.35 төгрөг

30.19%

Нэгтгэлийн дараах АПУ ХК  
Хувьцааны тоо: 1,064,181,553  
Нэрлэсэн үнэ: 10 мөнгө

100%

# НЭГТГЭХ ТӨСӨЛ

## 5.2 Нэгдэж байгаа Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хөрөнгийн хэмжээ

АПУ-гийн Хувьцаа эзэмшигчид Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар энэхүү Гэрээг, Нэгдлийг, АПУ-гийн Дүрэмд оруулах өөрчлөлтийг, Нэгдлийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай бусад холбогдох асуудлууд (түүний дотор АПУ-гийн Дүрэм буюу бусад зохицуулалтаар (бичгээр буюу бусад хэлбэрээр үйлдсэн) олгогдсон Шинэ Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах бүх давуу эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах болон үүгээр хязгаарлагдахгүй бусад)-ыг батална;

3.1.1.2. New Shares to be approved for registration by the MSE;

Нэмж гаргасан хувьцааг МХБ-д бүртгүүлэх шийдвэр гаргуулах;

3.1.1.3. based on the MSE decision, the FRC to confirm the reorganization through merger and authorize the registration of the New Shares;

МХБ-ийн бүртгэлийн шийдвэрт үндэслэн АПУ-ийн нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдан Нэмж Гаргасан Хувьцааг бүртгэх СЗХ-ны шийдвэрийг гаргуулах;

3.1.1.4. based on the FRC decision, the ownership rights of HAP over 266,091,981 APU Shares to be registered by the MCSD in the name of HAP and the ownership rights of MBI over 55,212,572 APU Shares to be registered by the MCSD in the name of MBI;

СЗХ-ны шийдвэрт үндэслэн ХАП-ын 266,091,981 ширхэг АПУ-ийн Хувьцааны өмчлөх эрх нь ХАП-ийн нэр дээр, МБИ-ийн 55,212,572 ширхэг АПУ-ийн Хувьцааг өмчлөх эрх нь МБИ-ийн нэр дээр тус тус Үнэт цаасны хадгаламжийн төвд бүртгэгдсэн байх;

## ARTICLE 3. MERGER CLOSING

### 3-Р ЗҮЙЛ. ДУУСГАВАР БОЛОХ АЖИЛЛАГАА

3.1.1.5. to register the Merger at the SRA;

Нэгтгэх Ажиллагаатай холбогдох бүртгэлийг УБГ-т хийлгэх;

3.1.1.6. where the terms of any material contract entered into by an APU Group Company contains any restrictions or prohibition on the change in control or shareholdings and/or the boards of directors of such APU Group Company, or includes any right to terminate exercisable prior to or as a result of any matter contemplated by this Agreement (including, for the avoidance of doubt, the Merger), written confirmation by the counterparties thereto (and if any conditions are imposed by such counterparties as a requirement for their waiver, such conditions being acceptable to Evergreen in its sole discretion), of the waiver of such restrictions or prohibition in relation to any such change arising from the transactions under this Agreement or of any such right to terminate, including but not limited to, the written confirmations of:

АПУ Группын компаниудын байгуулсан аливаа материаллаг гэрээний нөхцөлүүд тухайн компанийн хувьцаа эзэмшил эсвэл хяналтын эрх, ТУЗ-д өөрчлөлт оруулахыг хориглох буюу хязгаарлах эсвэл энэхүү Гэрээнд заасан аливаа үйл явдал (эргэлзэхгүй байх үүднээс түүний дотор Нэгдлийг оруулан) болохоос өмнө буюу түүний үр дүнд хэрэгжих цуцлалтын аливаа эрхийг тусгасан бол энэхүү гэрээнд заасан хэлцлийн дүнд гарах өөрчлөлттэй холбогдуулан уг эрхийг хэрэгжүүлэхгүй байхаа баталж гэрээний талуудын бичгээр өгөх зөвшөөрөл (болон ийнхүү зөвшөөрөл олгохын тулд шаардагдах нөхцөлүүд нь Эвэргрийний өөрийн үзэмжээр хүлээн зөвшөөрч болохуйц), түүний дотор:

- (a) König Ludwig International Verwaltungs GmbH (“König Ludwig”) pursuant to the Know-How, Technical Support and Trade Mark License Agreement No. 20130576 between König Ludwig and APU dated 16 September 2013; and

König Ludwig болон АПУгийн хооронд 2013 оны 09 сарын 16-ны өдөр байгуулсан Ноу-хау, техникийн дэмжлэг, Трейдмаркийн лицензийн гэрээ No. 20130576-ны дагуу König Ludwig International Verwaltungs GmbH (“König Ludwig”) -аас бичгээр авах зөвшөөрөл;

- (b) Mast-Jägermeister SE (“Jägermeister”) pursuant to the licence agreement between Jägermeister and APU dated 11 November 2015;

Jägermeister болон АПУ-гийн хооронд 2015 оны 11-р сарын 11-ний өдөр байгуулсан лицензийн гэрээний дагуу Mast-Jägermeister SE (“Jägermeister”);

## **ARTICLE 3. MERGER CLOSING**

### **3-Р ЗҮЙЛ. ДУУСГАВАР БОЛОХ АЖИЛЛАГАА**

3.1.1.7. in accordance with applicable laws and regulations, to notify the lenders and customers regarding APU's reorganization through the Merger;

АПУ-г нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсан талаар хуульд заасан журмын дагуу Зээлдүүлэгч болон бусад харилцагчдад мэдэгдэх;

3.1.1.8. to register changes of shareholder of each of the direct Subsidiaries of Evergreen with the SRA; and

Эвэргрийний Охин Компаниудын хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг УБГ-т бүртгүүлэх.

3.1.1.9. execution and handover report upon completion of the Merger by the Committees, described in Article 2.1.1 of this Agreement, to have been issued.

Гэрээний 2.1.1-д заасан Комисс нь Нэгтгэх Ажиллагааг гүйцэтгэсэн ажлын тайлан, акт үйлдсэн байх;

3.1.2. For Evergreen:

3.1.2. Эвэргрийнтэй холбоотойгоор:

3.1.2.1. Evergreen Shareholders to approve this Agreement, the Merger, and any ancillary matters as may be required to effect the Merger;

Эвэргрийний хувьцаа эзэмшигчид энэхүү Гэрээ, Нэгтгэх ажиллагаа болон Нэгтгэх ажиллагааг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай аливаа нэмэлт асуудлуудыг батлах;

3.1.2.2. to de-list Evergreen from the taxpayer registry; and

Эвэргрийнийг татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах;

3.1.2.3. to register the liquidation of Evergreen through merger and de-listing from the State Registry at the SRA.

Эвэргрийнийг нэгдэх замаар татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсаныг УБГ-т бүртгүүлэх;



## **ARTICLE 3. MERGER CLOSING**

### **3-Р ЗҮЙЛ. ДУУСГАВАР БОЛОХ АЖИЛЛАГАА**

#### 1.1. Responsibility for Satisfaction

##### Шаардлага хангах үүрэг хариуцлага

The Parties agree to cooperate with the provision of all requisite documents and materials, and with the taking of all actions, required to complete the registration and Merger Closing.

Талууд Нэгтгэх ажиллагааг дуусгавар болгоход болон бүртгэлийг бүрэн гүйцэт хийхэд шаардлагатай бүх баримт бичиг ба материалуудтай холбоотой заалт болон авах бүх арга хэмжээнд хамтран ажиллаж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

3.2.1 APU shall use its best endeavours to ensure the satisfaction of the conditions set out in Article 3.1.1 of this Agreement as soon as possible after the date of this Agreement.

АПУ энэхүү гэрээний 3.1.1-д заасан нөхцөл шаардлагыг энэхүү гэрээг байгуулсаны дараа нэн даруй хангахын төлөө боломжит хучин чармайлтаа гаргана.

3.2.2 Evergreen shall use its best endeavours to ensure the satisfaction of the conditions set out in Article 3.1.2 of this Agreement as soon as possible after the date of this Agreement.

Энэхүү гэрээг байгуулсны дараа түүний 3.1.2-т заасан нөхцөл шаардлагыг нэн даруй хангахын төлөө Эвэргрийн боломжит хучин чармайлтаа гаргана.

#### 1.2. Non-satisfaction/Waiver

##### Шаардлага хангаагүй байх/Шаардах эрхээ хэрэгжүүлэхгүй байх

3.3.1 The Party responsible for the satisfaction of each condition in Article 3.1 of this Agreement shall give notice to the other Party of the satisfaction of the relevant condition within two working days of becoming aware of the same.

Энэхүү гэрээний 3.1-д заасан нөхцөл шаардлага тус бүрийг хангах үүрэгтэй тал уг нөхцөлийг хангасан тухайгаа мэдсэнээс хойш ажлын хоёр хоногийн дотор нөгөө талдаа энэ тухай мэдэгдэл өгнө.

3.3.2 Evergreen may at any time waive in whole or in part and conditionally or unconditionally the conditions set out in Article 3.1.1 of this Agreement.

Эвэргрийн энэхүү гэрээний 3.1.1-д заасан нөхцөл шаардлагыг хангахыг шаардах эрхээ нөхцөлтэйгээр буюу нөхцөлгүйгээр хэрэгжуулэхгүй байх зөвшөөрлийг ямар ч үед өгч болно.

## **ARTICLE 3. MERGER CLOSING**

### **3-Р ЗҮЙЛ. ДУУСГАВАР БОЛОХ АЖИЛЛАГАА**

3.3.3 APU may at any time waive in whole or in part and conditionally or unconditionally the conditions set out in Article 3.1.2 of this Agreement.

АПУ энэхүү гэрээний 3.1.2-д заасан нөхцөл шаардлагыг хангахыг шаардах эрхээ нөхцөлтэйгээр буюу нөхцөлгүйгээр хэрэгжүүлэхгүй байх зөвшөөрлийг ямар ч үед өгч болно.

3.3.4 If the conditions in Article 3.1 of this Agreement are not satisfied or waived on or before the Merger Cut-off Date, save as expressly provided, this Agreement (other than the Surviving Provisions) shall lapse and no Party shall have any claim against the other under it, save for any claim arising from antecedent breaches of this Agreement.

Хэрэв энэхүү гэрээний 3.1-д заасан нөхцөл шаардлагыг Нэгдэх үйл ажиллагааг зогсоох өдөр буюу туунээс өмнө хангаагүй эсвэл хангахыг шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол илэрхий зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээ (хүчин төгөлдөр үлдэх заалтуудаас бусад хэсэг) дуусгавар болох бөгөөд гэрээ зөрчсөний улмаас үүсэх аливаа нэхэмжлэлээс бусад аливаа нэхэмжлэлийг аль ч тал ногоо талдаа гэрээний дагуу гаргахгүй.

## **ARTICLE 4. REPRESENTATIONS AND WARRANTIES**

### **4-Р ЗҮЙЛ МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА**

4.1. Each Party represents and warrants to the other as follows:

Талууд дараах мэдэгдэл, баталгааг гаргана.

4.1.1. Incorporation. It is, and each of its Subsidiaries is, a company duly incorporated and validly existing, and, if applicable, in good standing under the relevant laws of incorporation and registered, to the extent required in accordance with applicable law, with all relevant registration bodies in any jurisdiction in which it carries on business or owns assets and has full power to own the properties which it owns and to carry out the businesses which it carries out.

Бүртгэл. Талууд болон тэдгээрийн Охин компаниуд нь бөгөөд тэдгээр нь Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаагаа тогтмол явуулж буй, өөрийн үйл ажиллагааг явуулах буюу хөрөнгө өмчлөхөд шаардлагатай бүх эрх бүхий байгууллагуудад бүртгэгдсэн бөгөөд өөрийн өмчлөлд байгаа бүх хөрөнгийг өмчлөх, түүнчлэн үйл ажиллагаагаа эрхлэх бүрэн эрхтэй хуулийн этгээд болно;

4.1.2. Subsidiaries. It is the sole legal and beneficial owner of all the shares in the capital of (in the case of Evergreen only, save for SBB) its Subsidiaries and has the right to exercise all voting and other rights over such shares. Evergreen is the legal and beneficial owner of 97.197 per cent. of the common shares of SBB and has the right to exercise all voting and other rights over such shares.

Охин Компаниуд. Компани өөрийн Охин компаниудын хууль ёсны цорын ганц эзэмшигч (зөвхөн Эвэргрийний хувьд, СББ-аас бусад) бөгөөд эзэмшиж буй хувьцааныхаа саналын болон бусад бүх эрхийг хэрэгжүүлэх эрхтэй. Эвэргрийн СББ-ийн энгийн хувьцааны 97.197 хувийн хууль ёсны эзэмшигч бөгөөд эдгээр хувьцааны саналын болон бусад бүх эрхийг хэрэгжүүлэх эрхтэй.

4.1.3. Compliance with Law. Neither it, nor any of its Subsidiaries, is in violation of any law applicable to it and presently in effect. It is, and each of its Subsidiaries is, in compliance with all conditions and restrictions contained in the licenses required to operate its business.

Хууль тогтоомж дагаж мөрдөх. Талууд (тэдгээрийн Охин компаниуд) нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тэдгээрийн дагаж мөрдвөл зохих аливаа хууль тогтоомжийг зөрчөөгүй. Талууд (тэдгээрийн Охин компаниуд) нь тэдгээрийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл түүнийг авахад шаардлагатай аливаа нөхцөл, хориглолтыг дагаж мөрдөж байгаа болно;

## **ARTICLE 4. REPRESENTATIONS AND WARRANTIES**

### **4-Р ЗҮЙЛ МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА**

4.1.4. No Default. Neither it, nor any of its Subsidiaries, is in default under any agreement, obligation or duty to which it is a party or by which it or any of its properties or assets is bound.

Зөрчилгүй байх. Талууд болон түүний Охин компани нь хөрөнгөөрөө үүрэг хүлээсэн аливаа гэрээг зөрчөөгүй;

4.1.5. Litigation. Neither it, nor any of its Subsidiaries, is engaged in, or, to the best of its knowledge, threatened by, any litigation, arbitration or administrative proceeding, the outcome of which might have a material adverse effect.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Талууд (тэдгээрийн Охин компаниуд) нь материаллаг хэлбэрээр сөргөөр нөлөөлж болохуйц аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, арбитрын болон захиргааны хэрэгт оролцоогүй бөгөөд тийм ажиллагаа эхлүүлэхийг завдаагүй;

4.1.6. Corporate Power. It has the corporate power and authority to enter into, and perform its obligations under this Agreement, which when executed will constitute valid and binding obligations on it.

Хуулийн этгээдийн эрх. Талууд нь энэхүү Гэрээг байгуулах, тэдгээрт заасан үүргээ биелүүлэх хуулийн этгээдийн эрхтэй.

4.1.7. No Conflict. The execution and delivery of, and the performance by it of its obligations under, this Agreement will not result in violation of its charter or the constitutional documents of its Subsidiaries or any provision contained in any law applicable to it and its Subsidiaries.

Зөрчилгүй байх. Энэхүү Гэрээг байгуулж, түүний дагуу үүрэг хүлээж байгаа нь Охин компаниудын дүрэм болон үүсгэн байгуулах баримт бичиг буюу холбогдох аливаа хууль, тогтоомжийн заалтыг зөрчөөгүй;

4.1.8. Title to Assets. The shares which it holds in its Subsidiaries, their accompanying rights and obligations, underlying tangible and intangible assets are not subject to any lien.

Хөрөнгө өмчлөх эрх. Талуудын болон тэдгээрийн Охин компаниудад эзэмшиж буй хувьцаа, түүгээр илэрхийлэгдэх эрх, үүрэг, эдийн болон эдийн бус эд хөрөнгийн эрхүүд нь гуравдагч этгээдэд барьцаалагдаагүй, төлбөрийн үүрэг болон гуравдагч этгээдийн шаардлага үүсгэгдээгүй болно.

## **ARTICLE 4. REPRESENTATIONS AND WARRANTIES**

### **4-Р ЗҮЙЛ МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА**

4.1.9. Financial Statements. The unconsolidated balance sheets of it and its Subsidiaries individually all as at 31 December 2016 and the related income statements, statements of changes in equity, cash flow statement and notes, comprising a summary of significant accounting policies and other explanatory notes, of each such company, certified by the auditors, present fairly the financial positions, financial performance and cash flows of each such company. Since the date of such balance sheets, neither it, nor any of its Subsidiaries, has suffered any material adverse effect, incurred any substantial or unusual loss or liability or undertaken or agreed to undertake any substantial or unusual obligation.

Санхүүгийн тайлан. 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Талууд болон тэдгээрийн Охин компани тус бүрийн санхүүгийн тайлан үүнд: санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлого бусад тайлбарууд нь Аудитлагдсан бөгөөд Талууд тэдгээрийн Охин компаниудын санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлсэн болно. Дээрх санхүүгийн тайлангуудыг гаргасан өдрөөс хойш Талууд материаллаг хэлбэрээр сэргөөр нөлөөлж болохуйц аливаа гэнэтийн болон бодит алдагдал, өр төлбөр үүсгээгүй бөгөөд гэнэтийн болон бодит алдагдал, өр төлбөрийн үүрэг хүлээгээгүй болно.

## **ARTICLE 4. REPRESENTATIONS AND WARRANTIES**

### **4-Р ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА**

4.1.10. New Shares. In the case of APU only,

Шинэ Хувьцаа. Зөвхөн АПУ-ийн хувьд,

4.1.10.1 APU will on Merger Closing be entitled to allot and issue the full legal and beneficial ownership the New Shares to each of HAP and MBI in their respective proportions without the consent of any person;

Нэгтгэх Ажиллагаа Дуусгавар болгох өдөр АПУ нь зарласан бөгөөд гаргасан Шинэ Хувьцаануудыг ХАП болон МБИ-д тус бүрийн ногдох хувийн дагуу аливаа гуравдагч этгээдийн зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хууль ёсны өмчлөх эрхийг эзэмшүүлнэ;

4.1.10.2 the New Shares will not be encumbered or subject to the pre-emptive rights of any person;

Шинэ Хувьцаанууд нь барьцаалагдаагүй бөгөөд аливаа этгээдийн тэргүүн элжинд хэрэгжүүлэх эрхээс ангид байна;

4.1.10.3 the New Shares will be validly allotted and issued and credited as fully paid-up APU Shares which are not subject to further call; and

Шинэ Хувьцаанууд нь хүчин төгөлдөр зарласан бөгөөд гаргасан ба цаашид буцаан татах аливаа нөхцөлгүйгээр үнэ нь бүрэн төлөгдсөн АПУ-ийн Хувьцаагаар бүртгэгдсэн байна;

4.1.10.4 the New Shares will on Merger Closing comprise 30.19 per cent. of the enlarged share capital of APU.

Шинэ Хувьцаанууд нь нэгтгэсний дараах АПУ-ийн нийт хувьцаат капиталын 30.19 хувь байна.

## ARTICLE 5. UNDERTAKINGS

### 5-Р ЗҮЙЛ. ТОХИРОЛЦОО

- 5.1. Each Party shall use its best efforts in good faith to obtain at the earliest practicable date any approvals, authorizations and consents necessary, and shall take such actions as the other Party may reasonably request, to consummate the Merger and diligently attempt to satisfy, to the extent within its control, all conditions precedent to its obligations to close the Merger.

Талууд аливаа шаардлагатай зөвшөөрөл, бүрэн эрх болон зөвшөөрлийг хэрэгжүүлж болохуйц хамгийн эрт олж авахын тулд шударгаар тус тусын хүчин чармайлтыг гаргах ба Нэгтгэх ажиллагааг дуусгахын тулд бусад Талуудын үндэслэлтэйгээр шаардсан бусад арга хэмжээг авч, Нэгтгэх ажиллагааг дуусгавар болгох үүргүүдэд хамааралтай урьдчилсан нөхцөлүүдийг өөрийнхөө бүрэн эрх мэдлийн хүрээнд үнэнч шударгаар хангахын тулд чармайлт гаргана.

- 5.2. In no event shall any Party, without the prior written consent of the other Party, (a) agree to sell, divest, dispose of or hold separate any of its or its Subsidiaries' assets or businesses, or otherwise take or commit to take any action that could reasonably limit its or its Subsidiaries' freedom of action with respect to, or their ability to retain, one or more Subsidiaries, businesses, assets or affiliations or (b) agree or otherwise become subject to any restrictions, conditions, limitations, licensing requirements, or other understandings on or with respect to its or its Subsidiaries' assets or the operation of its or its Subsidiaries' business.

Бусад Талын урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа Тал нь ямар ч тохиолдолд (а) тухайн Тал эсхүл түүний аливаа Охин компаниудын аливаа хөрөнгө эсхүл бизнесийн үйл ажиллагааг худалдах, эдгээрийг өмчлөх эрхийг хасах, захиран зарцуулах эсхүл тусад нь байлгхааар зөвшөөрөхгүй эсхүл тухайн Тал эсхүл түүний Охин компаниудын нэг эсхүл түүнээс дээш тооны Охин компаниуд, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө эсхүл нэгдэл зэргийг авч үлдэх чадвар эсхүл тухайн Тал эсхүл түүний Охин компаниудын эдгээртэй холбоотой үйлдэл хийх эрх чөлөөг үндэслэлтэйгээр хязгаарлаж болох аливаа арга хэмжээг өөр бусад байдлаар авахгүй эсхүл авахаар санал гаргахгүй байх эсхүл (б) аливаа Тал эсхүл түүний аливаа Охин компаниудын хөрөнгө эсхүл бизнесийн үйл ажиллагаандахь эсхүл эдгээртэй холбоотой аливаа хязгаарлалт, нөхцөлүүд, хориглолт, тусгай зөвшөөрлийн шаардлагууд эсхүл бусад ойлголтуудыг хүлээн зөвшөөрөхгүй эсхүл өөр бусад байдлаар хамаарахгүй.

## ARTICLE 5. UNDERTAKINGS

### 5-Р ЗҮЙЛ. ТОХИРОЛЦОО

- 5.3. Each Party undertakes that between the date hereof and Merger Closing, except as contemplated hereby or with the prior consent of the other Party, it shall refrain from: (a) entering into any transaction with respect to its business other than in the ordinary course; (b) permitting any encumbrance, mortgage, pledge or lease of or on any material asset; (c) disposing of any material asset; or (d) incurring any material liabilities, other than indebtedness incurred in the ordinary course of business under already established credit facilities.

Энд авч хэлэлцсэн эсхүл бусад Талуудын урьдчилан зөвшөөрөл олгосныг үл оролцуулан Талууд нь энэхүү гэрээг байгуулсан өдөр болон Дуусгавар болгох ажиллагааны хооронд (а) ердийн үйл ажиллагаанаас бусад бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэлцэл байгуулах; (б) аливаа биет/бодит хөрөнгийн эсхүл түүн дэх аливаа гуравдагч этгээдийн эрх, зээлийн барьцаа, барьцаа эсхүл түрээсийг зөвшөөрөх; (в) аливаа биет/бодит хөрөнгийг захиран зарцуулах; эсхүл (г) бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад аль хэдийнэ авсан зээлийн санхүүжилтийн улмаас бий болсон өр төлбөрөөс бусдаар их хэмжээний өр төлбөр бий болгохоос татгалзана.

- 5.4. No Party shall issue any press release or make any such public statement regarding the Transactions without the prior written consent of the other Party, except as may be required by applicable Law after consultation with the other Party.

Талууд нь бусад Талуудтай хэлэлцсэний дараа холбогдох Хуулиар шаардсаныг үл оролцуулан бусад Талуудын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Хэлцлүүдтэй холбоотой аливаа хэвлэлийн мэдэгдэл хийхгүй эсхүл олон нийтэд аливаа мэдээлэл гаргахгүй.

- 5.5. From the date hereof until Merger Closing, each Party shall give the other Party prompt written notice, upon becoming aware of any event or circumstance that has resulted in, or could reasonably be expected to result in, a breach of, or inaccuracy in, any of the representations and warranties, or a breach of any covenant, made by such Party under this Agreement.

Энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс Дуусгавар болгох ажиллагаа хүртэл Талууд нь энэхүү Гэрээний дагуу тухайн Талын хийсэн аливаа мэдэгдэл ба баталгаа эсхүл хэлцлийг зөрчих эсхүл нарийн түвэгтэй байдалд хүргэсэн эсхүл үндэслэлтэйгээр хүргэж болох аливаа тохиолдол эсхүл нөхцөл байдлын талаар мэдмэгц бусад Талууддаа нэн даруй бичгээр мэдэгдэл өгнө.



## **ARTICLE 5. UNDERTAKINGS**

### **5-Р ЗҮЙЛ. ТОХИРОЛЦОО**

5.6. If prior to Merger Closing:

Нэгдлийг дуусгавар болгохоос өмнө:

5.6.1 any event shall occur which, in the opinion of Evergreen, is reasonably likely to result in the occurrence of a Material Adverse Event in respect of the Relevant SG Companies or the HAP Asset Companies, Evergreen shall be entitled to give written notice to APU of such event, and on the issuance of such notice, each of the Parties shall procure and ensure that Merger Closing shall not take place during the period of 75 days from the issuance of the notice (the “Extension Period”); and

Эвэргрийний үзэж байгаагаар ШГ-ын Харьяа Компаниуд эсвэл ХАП-ийн Харьяа Компаниудын хувьд Материаллаг сөрөг үйл явдал болохуйц үйл явдал болбол Эвэргрийн АПУ-д бичгээр уг үйл явдлын тухай мэдэгдэл өгөх эрхтэй бөгөөд ийм мэдэгдэл өгсөнөөр Тал тус бүр Нэгдлийг дуусгавар болгохгүй байхын төлөө арга хэмжээг мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 75 хоног (Сунгах хугацаа)-ийн дотор авах болон авахуулна;

5.6.2 in the event that the Extension Period ends on a date falling after the Merger Cut-Off Date, the Merger Cut-Off Date shall be extended to the last day of the Extension Period, and the term “Merger Cut-Off Date” as used herein shall, where applicable, include such extended period.

Хэрэв Сунгах хугацаа Нэгдэх Ажиллагаа зогсоох хугацааны дараа дуусах бол Нэгдэх Ажиллагаа зогсоох хугацааг Сунгах хугацааны сүүлчийн өдөр хүртэл сунгах бөгөөд Нэгдэх үйл явцыг зогсоох хугацаа гэсэн нэр томъёог энд хэрэглэсэн агуулгын дагуу ийнхүү сунгасан хугацааг оруулан ойлгоно.

## ARTICLE 5. UNDERTAKINGS

### 5-Р ЗҮЙЛ. ТОХИРОЛЦОО

For the avoidance of doubt:

Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс:

- (i) Evergreen shall only be entitled to exercise its right under Article 5.6.1 once; and  
Эвэргрийн 5.6.1-ийн дагуу эдлэх эрхээ зөвхөн ганц удаа л хэрэгжүүлэх эрхтэй байна;
- (ii) if:  
хэрэв:
  - (a) any event referred to in Article 5.6.1 results in the actual occurrence of a Material Adverse Event during the Extension Period; or  
5.6.1-д заасан аливаа үйл явдал Сунгасан хугацааны явцад Материаллаг сөрөг үйл явдалд бодитоор хүргэвэл; эсвэл
  - (b) any event (whether referred to in Article 5.6.1 or otherwise) occurs, whether during or after the Extension Period, which results in the actual occurrence of a Material Adverse Event before Merger Closing.  
Сунгасан хугацаанд буюу уг хугацааны дараа аливаа үйл явдал (5.6.1-д заасан буюу бусад хэлбэрээр) Нэгдэх Ажиллагааг дуусгавар болгохоос өмнө Материаллаг сөрөг үйл явдалд бодитоор хүргэвэл,

the provision of Article 5A shall apply.

5A заалт үйлчилнэ.

## ARTICLE 5A. TERMINATION

### ЗҮЙЛ 5A. ЦУЦЛАХ

If any Material Adverse Event occurs prior to Merger Closing, Evergreen shall be entitled (in addition to and without prejudice to all other rights or remedies available to it) by notice in writing to APU to terminate this Agreement (other than the Surviving Provisions).

Хэрэв Нэгдлийг дуусгавар болгохоос өмнө аливаа Материаллаг сөрөг үйл явдал тохиолдвол Эвэргрийн АПУ-д бичгээр мэдэгдэл өгсөнөөр энэхүү Гэрээг (хүчин төгөлдөр үлдэх заалтуудаас бусад хэсэг) цуцлах эрхтэй (өөрийн бусад эрх дээр нэмэлт болгож, бусад бүх эрх, арга хэмжээнд нөлөөлөхгүйгээр).

## **ARTICLE 6. MISCELLANEOUS**

### **6-Р ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ**

- 6.1. All notices and other communications under this Agreement shall be in writing and shall be deemed given when delivered personally to the Parties at the following addresses (or at such other address for a Party as shall be specified by notice in writing from such Party to the other Party).

Энэхүү Гэрээний дагуу бүх мэдэгдэл болон бусад харилцаа холбоог бичгээр үйлдэх бөгөөд дараах хаяг (эсхүл тухайн Талаас өгсөн мэдэгдэлд заасан аливаа бусад хаяг)-аар Талуудад биечлэн хүргүүлсэн тохиолдолд тэдгээрийг нөгөө Талд өгсөнд тооцно.

APU JSC  
Chinggis avenue 48, Khan Uul district,  
Ulaanbaatar 17040,  
Mongolia  
Attention: Chief Executive Officer

АПУ ХК  
[Чингисийн өргөн чөлөө 48, Хан-Уул дүүрэг]  
Улаанбаатар хот 17040  
Монгол улс  
Хүлээн авагч: Гүйцэтгэх захирал

Evergreen Investments LLC  
Chinggis avenue 48/1, Khan Uul district,  
Ulaanbaatar,  
Mongolia  
Attention: Chief Executive Officer

Эвэргрийн Инвестментс ХХК  
[Чингисийн өргөн чөлөө 48/1, Хан-Уул дүүрэг]  
Улаанбаатар хот  
Монгол улс  
Хүлээн авагч: Гүйцэтгэх захирал

## **ARTICLE 6. MISCELLANEOUS**

### **6-Р ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ**

- 6.2. Each provision of this Agreement will be interpreted so as to be effective and valid under applicable law, but if any provision is held invalid, illegal or unenforceable under applicable law, then such invalidity, illegality or unenforceability will not affect any other provision, and this Agreement will be reformed, construed and enforced as if such invalid, illegal or unenforceable provision never had been included in this Agreement.

Энэхүү Гэрээний аливаа заалтыг холбогдох хуулийн дагуу хүчин төгөлдөр бөгөөд хууль ёсны дагуу гэж тайлбарлах боловч хэрэв аливаа заалт нь холбогдох хуулийн дагуу хууль бус, хүчин төгөлдөр бус эсвэл хэрэгжүүлэх боломжгүй байвал тэрхүү хууль бус, хүчин төгөлдөр бус эсвэл хэрэгжүүлэх боломжгүй байдал нь аливаа бусад заалтад нөлөөлөхгүй бөгөөд тухайн хууль бус, хүчин төгөлдөр бус болон хэрэгжих боломжгүй заалтыг энэхүү Гэрээнд оруулж байгаагүй мэтээр энэхүү Гэрээг шинэчлэн найруулж, тайлбарлаж хэрэгжүүлнэ.

- 6.3. Any amendment hereto shall be in writing and signed by each Party. No waiver of any provision of this Agreement shall be valid unless in writing and signed by the Party against whom enforcement is sought.

Энэхүү Гэрээнд аливаа нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэх ба Талууд тус бүр гарын үсэг зурсан байна. Хэрэгжүүлэхээс татгалзаж буй Тал нь бичгээр үйлдэж гарын үсэг зураагүй тохиолдолд энэхүү Гэрээний аливаа заалтуудаас татгалзсан нь хүчин төгөлдөр болохгүй.

- 6.4. This Agreement shall be binding upon, and shall be enforceable by and inure to the benefit of, the Parties and their permitted respective heirs, legal representatives, successors and assigns; provided, however, that no Party may without the prior written consent of the other Party, assign, grant any security interest over, hold on trust or otherwise transfer the benefit of the whole or any part of this Agreement.

Энэхүү Гэрээ нь Талууд болон тэдгээрийн зөвшөөрсөн холбогдох өв залгамжлагчид, хуулийн төлөөлөгчид, эрх залгамжлагчид болон эрх шилжүүлэн авагчдын хувьд заавал биелүүлэх хуулийн хүчинтэй бөгөөд тэдгээрийн ашиг тусын тулд хүчин төгөлдөр хэрэгжих боловч аливаа Тал нь энэхүү Гэрээг (хуульд зааснаас бусад тохиолдолд) нөгөө Талын урьдчилан бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй бөгөөд аливаа зөвшөөрөлгүйгээр шилжүүлэхийг завдсан нь хүчин төгөлдөр бус байх бөгөөд ямарваа нэгэн үйлчлэлгүй байна.

## **ARTICLE 6. MISCELLANEOUS**

### **6-Р ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ**

- 6.5. Subject to Article 6.6 of this Agreement, each Party shall bear all costs and expenses incurred by it in connection with the preparation, negotiation and entry into this Agreement and the Merger.

Энэхүү гэрээний 6.6-д зааснаас бусад нөхцөлд энэхүү гэрээг байгуулахтай холбоотой болон Нэгдэх ажиллагаатай холбоотой гарсан тус тусын зардлыг Талууд өөрөө хариуцна.

- 6.6. APU shall bear the cost of all stamp duty, any notarial, registration fees and other costs and liabilities required under relevant laws in relation to the issuance of the New Shares, the Merger and Subsidiary registration.

Шинэ Хувьцаа гаргах, Нэгдэх болон Охин компаниудыг өөрийн хувь эзэмшилд бүртгүүлэхтэй холбогдон гарах аливаа тэмдэгтийн хураамж, бүртгэлийн хураамж, нотариатын зардал болон хуулийн дагуу төлөх ёстой бүх төрлийн зардлыг АПУ хариуцан төлнө.

- 6.7. The Agreement shall be governed by, and construed in accordance with, the laws of Mongolia.

Энэхүү Гэрээг Монгол улсын хуулийн дагуу зохицуулж тайлбарлана.

- 6.8. Any disputes arising in relation to this Agreement shall be submitted for resolution to the courts of Mongolia.

Гэрээтэй холбоотой аливаа маргаан үүсвэл уг маргааныг Талууд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 6.9. This Agreement may be executed in counterparts, all of which shall be considered one and the same agreement and shall become effective when one or more counterparts have been signed by each Party and delivered to the other Party.

Энэхүү Гэрээг хэдэн ч хувь үйлдэж болох бөгөөд тэдгээр нь нэг баримт бичигт тооцогдох ба тухайн Тал нь нэг эсхүл түүнээс дээш хувьд гарын үсэг зурж нөгөө Талдаа хүргүүлсэнээр хүчин төгөлдөр болно.

- 6.10. This Agreement is executed in Mongolian (as accompanied by an English translation which is a true and accurate translation of the Mongolian text).

Энэхүү гэрээг Монгол хэлээр (Монгол хэл дээрх үг хэллэгийг зөв бөгөөд утга агуулгыг бүрэн орчуулсан Англи хэл дээрх орчуулгыг хавсаргасан) байгуулсан болно.

[SIGNATURE PAGE]  
ГАРЫН ҮСГИЙН ХУУДАС

WITNESS the following signatures.  
ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН дор гарын үсэг зурав.

APU JSC, a Mongolian incorporated joint stock company  
АПУ ХК, Монголын хувьцаат компани

Signature \_\_\_\_\_  
[NAME]  
[POSITION]

COMPANY STAMP]

Гарын үсэг \_\_\_\_\_  
ТАМГА]  
[НЭР]  
[АЛБАН ТУШААЛ]

[КОМПАНИЙН

[SIGNATURE PAGE]  
ГАРЫН ҮСГИЙН ХУУДАС

Evergreen Investments LLC, a Mongolian incorporated limited liability company  
Эвэргрийн инвестментс ХХК, Монголын хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

Signature \_\_\_\_\_ [COMPANY  
STAMP] [NAME]  
[POSITION]

Гарын үсэг \_\_\_\_\_ [КОМПАНИЙН  
ТАМГА] [НЭР]  
[АЛБАН ТУШААЛ]

Schedule 1 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_ сарын \_\_ний  
өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 1

**SCHEDULE 1. MBC ASSETS**  
**(Summary)**  
**ХАВСРАЛТ 1. М БИ СИ-ИЙН ХӨРӨНГӨ**  
**(Хураангуй)**

**1. Investment-in Subsidiaries / Хувьцаагаарх хөрөнгө оруулалт**

№	Investment-in /Хувьцаагаарх хөрөнгө оруулалт	Share ownership / Хувь эзэмшлийн байдал
1	SBB/ СББ	97.197 %
2	SBB Trading/ СББ Трейд	100%
3	MCS APB/ М Си Эс Эй Пи Би	55%



Schedule 2 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
 АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_ сарын \_\_ ний  
 өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 2

**SCHEDULE 2. MCS-APB ASSETS**

(Summary)

ХАВСРАЛТ 2. М СИ ЭС- ЭЙ ПИ БИ-ИЙН ХӨРӨНГӨ  
 (Хураангуй)

**1. License/ Тусгай зөвшөөрөл:**

№	Owner/ Эзэмшигч	License/ Тусгай зөвшөөрлийн нэр	Authorized place/ Эрх олгосон газар	Registration Date/ Эрх олгосон огноо	Term/ Эрхийн хугацаа
1	MCS-APB / М СИ ЭС- ЭЙ ПИ БИ	Beer produc- tion/ Шар айраг үйлдвэрлэх	Ministry of food, agricul- ture and light industry/ Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2016.07.28	3 years/ 3 жил
2	MCS-APB / М СИ ЭС- ЭЙ ПИ БИ	Beer import/ Шар айраг импортлох	Ministry of food, agricul- ture and light industry/ Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2017.04.03	2 years/ 2 жил

## 2. Immovable property/ Үл хөдлөх эд хөрөнгө

№	Owner / Эзэмшигч	Address of Property / Эд хөрөнгийн байршил	Property Description / Талбайн хэмжээ	Property and Certificate Number / Гэрчилгээний болон улсын бүртгэлийн дугаар	Date of Certificate Issue / Огноо	Purpose/ Зориулалт
1	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, 10th Khoroo, 13260, Gachuurt Road 102, 102/1, 102/2, 102/3, 102/4, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, 13260 Гачууртын. Зам, 102, 102/1, 102/2, 102/3, 102/4,	10,382 m <sup>2</sup>	Y-2204022625	2012.10.05	Production, Office, Warehouse, Boiler house/ Үйлдвэрлэл, албан газар, агуулах, чанах цех
2	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, 10th Khoroo, Amgalan /13260/ Gachuurt Road, 102/5, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, /13260/ Гачууртын. Зам, 102/5,	1,197m <sup>2</sup>	Y-2204076061	2015.11.24	Garage / Граж
3	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, 10th Khoroo, Amgalan /13260/ Gachuurt Road 102/6, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг, амгалан /13260/ Гачууртын. Зам 102/6,	214.28 m <sup>2</sup>	Y-2204074483	2015.09.16	Warehouse / Агуулах
4	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, 10th Khoroo, Amgalan /13260/ Gachuurt Road, 102/2, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг, амгалан /13260/ Гачууртын. Зам, 102/2,	144 m <sup>2</sup>	Y-22040755436	2015.11.23	Training facility/ Сургалтын барилга
5	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, 10th Khoroo, Amgalan /13260/ Gachuurt Road, 102/7, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг, амгалан /13260/ Гачууртын. Зам, 102/7,	1,036.73 m <sup>2</sup>	Y-2204081178	2016.04.12	Warehouse / Агуулах

### 3. Land use rights/ Газар ашиглах эрх

№	Possessor/ Эзэмшигч	Land Location/ Газрын байршил	Certificate Number/ газар ашиглах гэрчилгээний дугаар	Land Area/ Газрын талбайн хэмжээ /м.кв/	Date of Certificate Issue/ ашиглах эрх олгосон огноо	Term/ Эрхийн хугацаа	Purpose/ Зориулалт
1	MCS-APB / М СИ ЭС-ЭЙ ПИ БИ	Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Баянзүрх дүүрэг	0000955	50,000.00 square metres/ 50,000.00 м.кв	2009.05.05	60 жил	Manufacturing, Office / Үйлдвэрлэл, оффис

### 4. Intellectual property/ Оюуны өмчийн эрх

№	Intellectual property/ Оюуны өмч	Quantity of certificate/ Гэрчилгээний тоо хэмжээ
1	Registered trademark / Монголын Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг	12
2	Trademark license / Барааны тэмдэг ашилах эрхийн лиценз	2

### 5. Equipments/ Тоног төхөөрөмж

№	Equipment/ Тоног төхөөрөмж	Capacity/ Хүчин чадал
1	Malt handling equipment/ тоног төхөөрөмж	1.5 ton/h / 1.5 тонн /1 Цагт/
2	Brewhouse equipment/ тоног төхөөрөмж	110 hl / 11000 литр
3	Fermentation tanks/ Исгэлтийн танк	18000 hl / 180000 литр
4	Filtration equipment/ Шүүлтүүр	150hl/h / 1500 литр /1 цагт/
5	Bright beer tanks / Шар айрагны танк	5000 hl / 500000 литр
6	Bottling line/ Савлах шугам /лонх/	15000 bph / 15000 шил
7	Canning line / Савлах шугам /лааз/	15000 cph / 15000 лааз
8	Kegging line / Савлах шугам /торх/	30 kph / 30 торх

Schedule 2 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
 АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_\_ сарын \_\_\_ний  
 өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 3

**SCHEDULE 3. UB SPIRIT ASSETS**  
 (Summary)

**ХАВСРАЛТ 3. УБ СПИРТ ИЙН ХӨРӨНГӨ**  
 (Хураангуй)

**1. License/ Тусгай зөвшөөрөл**

№	Owner/ Эзэмшигч	License/ Тусгай зөвшөөрлийн нэр	Authorized place/ Эрх олгосон газар	Registration date/ Эрх олгосон огноо	Term/ Эрхийн хугацаа
1	UB spirit / УБ спирт	Spirit produc- tion/ Спирт үйлдвэрлэх	Ministry of Food, Ag- riculture and Light In- dustry / Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2016.04.13	3 years/ 3 жил

**2. Immovable property/ Үл хөдлөх эд хөрөнгө**

№	Owner/ Эзэмшигч	Address of Property / Эд хөрөнгийн байршил	Property Descrip- tion/ Талбайн хэмжээ	Property and Certificate Number/ Гэрчилгээний болон улсын бүртгэлийн дугаар	Date of Certificate Issue / Огноо	Purpose/ Зориулалт
1	UB spirit / УБ спирт	Tolgoit 104/13, Song- ino-Khairkhan District, 4th khoroo, Ulaan- baatar, Mon- golia/ УБ хот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Толгойтын 104/13	3606 sq meters / 3606 мк.в	000400301 Ү-2201005233	2015.03.17	Factory/ Үйлдвэр

### 3. Land possession right/ Газар эзэмших эрх

№	Pos- sessor/ Эзэмшигч	Land Location/ Газрын байршил	Certificate Number/ газар ашиглах гэрчилгээ- ний дугаар	Land Area/ Газрын талбайн хэмжээ /м.кв/	Date of Certifi- cate Issue/ ашиглах эрх олгосон огноо	Term/ Эрхийн хугацаа	Purpose/ Зориулалт
1	UB spirit /УБ спирт	Songi- no-Khairkhan District, Khoroo 4, Ulaanbaatar, Mon- golia / УБ хот, Сонгинихайрхан дүүрэг,4-р хороо	000317480	3074 meters /3074 м.кв	2016. 01.08	9 жил	Produc- tion, service/ Худалдаа, үйлчилгээ

### 4. Equipments/ Тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж/ Equipment	Хүчин чадал (хоногт) (capacity/day)
1	Boiling unit equipment/ Чаналгын цехийн тоног төхөөрөмж	216,000m <sup>3</sup> / 216,000 м <sup>3</sup>
2	Fermenting unit/ Исгэлтийн цехийн тоног төхөөрөмж	216,000m <sup>3</sup> / 216,000 м <sup>3</sup>
3	Distilling unit/ Нэрлэгийн цехийн тоног төхөөрөмж	12,800 litres/ 12,800 литр

Schedule 4 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
 АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_ сарын \_\_ний  
 өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 4

**SCHEDULE 4. APU TRADING ASSETS**  
 (Summary)

**ХАВСРАЛТ 4. АПУ ТРЕЙДИНГИЙН ХӨРӨНГӨ**  
 (Хураангуй)

**1. Investment-in Subsidiaries / Хувьцаагаарх хөрөнгө оруулалт**

№	Investment-in/ Хөрөнгө оруулалт	Share ownership/ Хувь эзэмшлийн байдал
1	DEPOD/ ДЕПОД	100%

**2. Licence/ Тусгай зөвшөөрөл**

№	Owner/ Эзэмшигч	License/ Тусгай зөвшөөрлийн нэр	Authorized place/ Эрх олгосон газар	Location/ Байршил	Date of Certificate Issue / Огноо	Term/ хугацаа
1	APU Trading/ АПУ Трейдинг	Special licence for sale of alcohol/ Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах	The Mayor's Office of Ulaanbaatar/ Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Chingeltei district, grocery store/ Чингэлтэй дүүрэг, Нэрийн барааны дэлгүүр	2015.08.06	2 years/ 2 жил
2	APU Trading/ АПУ Трейдинг	Special licence for sale of alcohol/ Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах	The Mayor's Office of Ulaanbaatar/ Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Sukhbaatar district, grocery store/ Сүхбаатар дүүрэг, Нэрийн барааны дэлгүүр	2015.08.06	2 years/ 2 жил
3	APU Trading/ АПУ Трейдинг	Special licence for sale of alcohol/ Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах	The Mayor's Office of Ulaanbaatar/ Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Khan-Uul district, Grocery store/ Хан-Уул дүүрэг, Хүнсний дэлгүүр	2015.08.06	2 years/ 2 жил
4	APU Trading/ АПУ Трейдинг	Special licence for sale of alcohol/ Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах	The Mayor's Office of Ulaanbaatar/ Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Khan-Uul district, grocery store/ Хан-Уул дүүрэг, Нэрийн барааны дэлгүүр	2016.11.14	2 years/ 2 жил

### 3. Immoveble property/ Үл хөдлөх эд хөрөнгө

№	Owner/ Эзэмшигч	Address of Property / Эд хөрөнгийн байршил	Property Description/ Талбайн хэмжээ	Property and Certificate Number/ Гэрчилгээний болон улсын бүртгэлийн дугаар	Date of Certificate Issue / Огноо	Purpose/ Зориулалт
1	APU Trading/ АПУ Трейдинг	Sukhbaatar District, 7th khoroo, Irkutsk Street / УБ хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Иркутскийн гудамж	66,72 sq Meters/ 66,72 м.кв	000091273 Ү-2203007031	2010.01.15	Service/ Үйлчилгээ
2	APU Trading/ АПУ Трейдинг	Khan-Uul District, 4th khoroo, Viva City Building 3/24 / УБ хот, Хан-Уул дүүрэг, 2р хороо Вива Сити хороолол, 3/24	229,39 sq Meters/ 229,39 м.кв	000365982 Ү-2206027973	2015.01.14	Service/ Үйлчилгээ
3	APU Trading/ АПУ Трейдинг	Khan-Uul District, 4th khoroo, Viva City Building 3/24 / УБ хот, Хан-Уул дүүрэг, 2р хороо Вива Сити хороолол, 3/24	249 sq Meters/ 249 м.кв	000365960 Ү-2206027803	2015.01.14	Service/ Үйлчилгээ
4	APU Trading/ АПУ Трейдинг	Bayangol District, 9th khoroo, Gorky 16th Street, door No.369/ Баянгол дүүрэг, 9-р хороо, Горкигийн 16 дугаар гудамж, дугаар 369	104,8 sq Meters/ 104,8 м.кв	000132764 Ү-2205027914	2011.02.28	Service, warehouse/ Агуулах, үйлчилгээний
5	APU Trading/ АПУ Трейдинг	Orkhon province, Bayan-Undur soum, Mining team, Kuwait Street, in front of Danista Market/ Орхон аймаг, Баян-Өндөр сум, Кувейт гудамж	1668,4 sq Meters/ 1668,4 м.кв	000190520 Ү-2101015567	2012.11.26	Service, apartment/ Үйлчилгээ
6	APU Trading/ АПУ Трейдинг	Bayangol District, 9th khoroo, Gorky 16th Street, door No.369/ Баянгол дүүрэг, 9-р хороо, Горкийн гудамж 15, 369 тоот	128 sq meters/ 128 м.кв	000132763 Ү-2205019357	2011.02.28	House/ Байр

#### 4. Land possession right/ Газар эзэмших эрх

№	Possessor/ Эзэмшигч	Land Location/ Газрын байршил	Certificate Number/ газар ашиглах гэрчилгээ- ний дугаар	Land Area/ Газрын талбайн хэмжээ /м.кв/	Date of Certifi- cate Issue/ ашиглах эрх олгосон огноо	Term/ Эрхийн хугацаа	Purpose/ Зориулалт
1	APU Trad- ing/ АПУ ТРЕЙДИНГ	Sukhbaatar District 7th Khoroo, Irkutsk Street / УБ хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж	0228375	81 sq me- ters/ 81 м.кв	2016. 04.18	5 years/ 5 жил	Trade and service/ Худалдаа, үйлчилгээ

#### 5. Quantity of sales vehicles /Борлуулалтын машин

№	Машин	Quantity/ Тоо хэмжээ
1	Sales vehicles Борлуулалтын машин	79



Schedule 5 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
 АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_ сарын \_\_ ний  
 өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 5

**SCHEDULE 5. NATUR AGRO ASSETS**  
 (Summary)  
 ХАВСРАЛТ 5. НАТУР АГРО-ГИЙН ХӨРӨНГӨ  
 (Хураангуй)

**1. Immovable property/ Үл хөдлөх эд хөрөнгө**

№	Owner/ Эзэм- шигч	Address of Property / Эд хөрөнгийн байршил	Property Descrip- tion/ Талбайн хэмжээ	Property and Cer- tificate Number/ Гэрчилгээний болон улсын бүртгэлийн дугаар	Date of Cer- tificate Issue / Огноо	Purpose/ Зориулалт
1	Natur Agro / Натур- Агро	Uildver street-79, Uildver-1 /17062/ Khoroo 3, Khan- Uul district, Ulaanbaatar/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, /17062/ Үйлдвэрийн гудамж-79ь Үйлдвэр 1	1200 sq meters/ 1200 м.кв	000214561 Y-2206009300	2012. 09.24	Office build- ing/ Оффис- ийн
2	Natur Agro / Натур- Агро	Uildver Street-77, Uildver-1 /17062/ Khoroo 3, Khan- Uul district, Ulaanbaatar/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо /17062/ Үйлдвэрийн гудамж-79, Үйлдвэр 1	1200 sq meters/ 1200 м.кв	000214562 Y-2206009302	2012. 09.24	Production fa- cility building/ Үйлдвэрийн байгуу-ламж
3	Natur Agro / Натур- Агро	Uildver Street-81, Uildver-1 /17062/ Khoroo 3, Khan- Uul district, Ulaanbaatar/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо /17062/ Үйлдвэрийн гудамж-81, Үйлдвэр 1	3060 sq meters/ 3060 м.кв	000214563 Y-2206009301	2012. 09.24	Warehouse/ Аргуулах
4	Natur Agro / Натур- Агро	Uildver Street-79/1, /17062/ Khoroo 3, Khan- Uul district, Ulaanbaatar/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо /17062/ Үйлдвэрийн гудамж-79/1	2000 tons/ 2000 tons	000215042 Y-2206021547	2012. 08.10	Warehouse silos/ Аргуулах
5	Natur Agro / Натур- Агро	Uildver Street-77/1, /17062/ Khoroo 3, Khan- Uul district, Ulaanbaatar/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо /17062/ Үйлдвэрийн гудамж-77/1	1707 sq meters/ 1707 м.к.в	000215043 Y-2206021548	2012. 08.10	Production fa- cility building/ Үйлдвэрийн байгуу-ламж

## 2. Land possession rights/ Газар эзэмших эрх

№	Эзэмшигч	Газрын байршил	Эзэмших эсхүл ашиглах гэрчилгээний дугаар	Газрын талбайн хэмжээ /м.кв/	Эзэмших эсхүл ашиглах эрх олгосон огноо	Эрхийн хугацаа	Зориулалт
1	Natur Agro / Натур-Агро	3rd Khoroo, Khan-Uul district, Ulaanbaatar, Mongolia/ УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо	000318877	21712 sq meters/ 21712 м.кв	2017.02.26	5 years/ 5 жил	Production/ Үйлдвэрлэл

## 3. Equipments/Тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж/ Equipment	Хүчин чадал (хоногт) (capacity/day)
1	Spirit factory's fermenting equipments/ Спиртийн үйлдвэрийн хөрөнгө исгэх болон ариутгалын тоног төхөөрөмж	15,000 litres/15,000 литр
2	Spirit factory's laboraty's equipments/ Спиртийн үйлдвэрийн лабораторийн тоног төхөөрөмж	
3	Spirit factory's Carbon dioxide equipments/ Спиртийн үйлдвэрийн нүүрсхүчлийн хийн тоног төхөөрөмж	
4	Spirit factory's distilling equipments/ Спиртийн үйлдвэрийн нэрлэгийн тоног төхөөрөмж	
5	Spirit factory's extension- fermenting equipment/ Спиртийн үйлдвэрийн өргөтгөлийн чаналга исгэлтийн тоног төхөөрөмж	23,000 litres/ 23,000 литр
6	Spirit factory's extension- producing flour equipment/ Спиртийн үйлдвэрийн өргөтгөлийн гурилын цехийн тоног төхөөрөмж	
7	Spirit factory's extension- distilling equipment/ Спиртийн үйлдвэрийн өргөтгөлийн нэрлэгийн тоног төхөөрөмж	
8	Spirit factory's extension- distilling equipment/ Спиртийн үйлдвэрийн өргөтгөлийн нэрлэгийн тоног төхөөрөмж	

Schedule 6 to the Merger Agreement dated 2017 between APU and Evergreen  
 АПУ, Эвэргрийн нарын байгуулсан 2017 оны \_\_ сарын \_\_ ний  
 өдрийн Нэгтгэх гэрээний Хавсралт 6

**SCHEDULE 6. SBB ASSETS**  
 (Summary)  
 ХАВСРАЛТ 6. СББ-ИЙН ХӨРӨНГӨ  
 (Хураангуй)

**1. Licence/ Тусгай зөвшөөрөл**

